



109

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 344


Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөр, “Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Эрүүл мэндийн сайдын 375 дугаар тушаалын 5 дугаар зүйлийн биелэлтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. “Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээний удирдамж”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээг 2013 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн орон даяар хэрэгжүүлэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.
3. Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээний гүйцэтгэл, хэрэгжилтэнд хяналт тавих шалгуур үзүүлэлтийг боловсруулж Сайдын зөвлөлд танилцуулж, албажуулан 2013 оны 11 дүгээр сарын 01-ний дотор батлуулж мөрдүүлэхийг Хяналт шинжилгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.
4. Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээг эрүүл мэндийн бүх байгууллагад нэвтрүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяад)-даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

110

Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 09 дугаар сарын 19-ны  
өдрийн 344 дүгээр тушаалын  
хавсралт

## СЭТГЭЛД НИЙЦСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН НАЙМАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. “Сэтгэлд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” гэж эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл, орчин, эрүүл мэндийн ажилтнуудын харилцаа хандлага, ажлын нөхцөл, тусламж, үйлчилгээний хүрэлцээ, хүртээмж, цаг хугацаа, чанар, аюулгүй байдал нь иргэд үйлчлүүлэгчдийн хүссэн хүлээлтийг бүрэн хариулж, сэтгэл ханамжийн баталгааг өгч чадах тусламж, үйлчилгээг хэлнэ.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын үнэт зүйл гэж байгууллагын эрхэмлэн дээдэлж буй эрхэм зорилго, нэр хүндийн баталгааг хэлнэ.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын орчин гэж байгууллагын гадаад, дотоод орчин, тусламж, үйлчилгээ үзүүлж буй тасаг нэгжийн орчинг хэлнэ.

1.4. Эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлага гэж иргэд, үйлчлүүлэгчдийг хүлээж авах, уулзах, ярилцах, үзлэг, шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх, сэргээн засах, эмчлэх, сувилах үедээ хандаж байгаа эрүүл мэндийн ажилтны хандлага, үг ярианы болон зан харилцааны байдлыг хэлнэ.

1.5. Эрүүл мэндийн ажилтны ажлын нөхцөл гэж эрүүл мэндийн ажилтны иргэд үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ хийх, эмчлэх, сувилах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өрөө тасалгааны тав тухтай байдал, хувь хүний нэр төр, эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалах, итгэл үнэмшил төрүүлэх байдлыг хэлнэ.

1.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрэлцээ гэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт шаардлагатай тусламж, үйлчилгээг авах боломжтой байхыг хэлнэ.

1.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт шаардлагатай тусламж, үйлчилгээ нь хүртэж байхыг хэлнэ.

1.8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар гэж иргэд үйлчлүүлэгчдийн нас, биеийн онцлог, эрүүл мэндийн байдал, өвчин эмгэгийн онош, үе шатанд нийцсэн, эрсдэлгүй, үр дүнтэй, сэтгэл ханамж өндөртэй тусламж, үйлчилгээг хэлнэ.

1.9. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал гэж иргэд, үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх үед эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтны хайнга, хайхрамжгүй байдал, мэдлэг, ур чадварын дутагдлаас болж аливаа эрсдэл, хохирол гарахгүй байхыг хэлнэ.

1.10. Сэтгэлд нийцсэн найман үйлчилгээ гэж сэтгэлд нийцсэн угтах, эргэх, лавлах, зөвлөх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнүүдийг хэлнэ.

## Хоёр. Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ

2.1. Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ гэж эрүүл мэндийн байгууллага бүр ирсэн иргэд, үйлчлүүлэгчийг “Зочин” хэмээн хүндэлж, тосон авч мэндлэн, тусламж үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай авахад нь дэмжлэг болох мэдээллээр хангаж, чиглүүлж өгөх, үйлчилгээ аваад гарах үед нь талархалаа илэрхийлж үдэж өгөх үйлчилгээг хэлнэ.

2.2. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх цэгтэй байх ба энэ цэг нь иргэд, үйлчлүүлэгчдийн орж ирэх хаалганы ойролцоо байрласан байна.

2.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ”-ний удирдамжтай байна.

2.4. “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ”-ний удирдамж нь ажилтны хувцаслалт, зан харилцаа, угтах, үдэх үйлчилгээ үзүүлэх үед шаардагдах мэдээлэл, мэдлэг, ур чадвар, журмыг багтаасан байна.

2.5. “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ” үзүүлэх ажилтныг урьдчилан тухайн байгууллагын үйл ажиллагаа, онцлог болон шаардагдах мэдээлэл, “Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ”-ний удирдамжийг багтаасан чиглүүлэх сургалтанд хамруулж, гэрчилгээжүүлсэн байна.

## Гурав. Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ

3.1. “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ” гэж эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний болон өвчтөн, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн асуудлаар иргэд, үйлчлүүлэгч, ар гэрийнхэн, найз нөхөд нь мэдээллийн лавлагаа авах үед нь шаардлагатай мэдээллийг өгөх үйлчилгээг хэлнэ.

3.2. Эрүүл мэндийн байгууллага бүр иргэд, үйлчлүүлэгчид утсаар, бичгээр болон аман хэлбэрээр аливаа мэдээллийг лавлаж асуух асуултанд хариулж, үйлчилгээ үзүүлэх лавлах цэгтэй байна.

3.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ”-ний удирдамжтай байна.

3.4. “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ”-ний удирдамж нь лавлагаа өгөх тусламж, үйлчилгээний төрөл, тэдгээрийн тухай лавлагаа өгөх мэдээллийн сан, лавлагаа өгч байгаа ажилтны ажлын байрны тодорхойлолт, ажиллах журмыг багтаасан байна.

3.5. “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ” үзүүлэх ажилтныг урьдчилан тухайн байгууллагын үйл ажиллагаа, онцлог болон шаардагдах мэдээлэл, “Сэтгэлд нийцсэн лавлах үйлчилгээ”-ний удирдамжийг багтаасан чиглүүлэх сургалтанд хамруулж, гэрчилгээжүүлсэн байна.

## Дөрөв. Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ


4.1. “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ” гэж эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнг ар гэрийнх нь хүмүүс эргэж ирэх үед эргэлт ирсэн тухай мэдээллийг өвчтөнд мэдээлэх, эргэлтээр ирсэн хүнийг өвчтөнтэй уулзах уулзалтыг ая тухтай байдалд зохион байгуулах үйлчилгээг хэлнэ.

4.2. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнг түүний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, төрөл төрөгсөд нь эргэж ирэх үед уулзалтыг ая тухтай, ариун цэврийн шаардлага хангасан нөхцлийг бүрдүүлэн зохион байгуулсан байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ”-ний удирдамжтай байна.

4.4. “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ”–ний удирдамж нь эргэлтийн цагийн хуваарь, эргэлт ирсэн тухай мэдээлэл, эргэлтийн байрны ажиллах журам зэргийг багтаасан байна.

4.5. “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ” үзүүлэх ажилтныг “Сэтгэлд нийцсэн эргэх үйлчилгээ”–ний удирдамжийн чиглүүлэх сургалтанд хамруулж, гэрчилгээжүүлсэн байна.



#### Тав. Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ

1.1. “Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ” гэж урьдчилан сэргийлэх, эмчилж, сувилах, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх үедээ эрүүл мэндийн ажилтнууд иргэд үйлчлүүлэгчдэд тэдний хэрэгцээ, шаардлагад тулгуурлан, шинжлэх ухааны үндэстэй, итгэл төрүүлэхүйц, эргэлзээ, бухимдал үүсгэхээргүй, үнэн зөв мэдээлэл өгөх үйлчилгээг хэлнэ.

1.2. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ”–ний удирдамжтай байна.

1.3. “Сэтгэлд нийцсэн зөвлөх үйлчилгээ”–ний удирдамж нь ажилтнуудыг иргэд үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн асуудлыг бүрэн мэдэх, мэдээлэл солилцох, зөвлөгөө өгөх ур чадварт сургахад чиглэгдэнэ.

1.4. Эрүүл мэндийн нийт ажилтныг зөвлөх үйлчилгээний сургалтанд хамруулах ажлыг эрүүл мэндийн байгууллага бүр хариуцна.

1.5. Эрүүл мэндийн ажилтнуудыг иргэд үйлчлүүлэгчид зөвлөлгөө өгөх үедээ хувийн болон байгууллагын дотоод асуудал, хов жив ярилгүй зөвхөн үйлчлүүлэгчид бүх анхаарлаа төвлөрүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад чиглэсэн зөвлөлгөө өгөх ур чадвартай болгохыг эрүүл мэндийн байгууллага бүр эрхэмлэн ажиллана.

#### Зургаа. Сэтгэлд нийцсэн оношилгоо

6.1. “Сэтгэлд нийцсэн оношилгоо” гэж иргэд, үйлчлүүлэгч өвчин эмгэгээ оношлуулахаар эрүүл мэндийн байгууллагад хандах үед хүлээгдэл, чирэгдэлгүйгээр үзлэг шинжилгээнд хамруулж, өвчтөний оношийг хугацаа алдалгүй, үнэн зөв тогтоож чадах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэлнэ.

6.2. Эрүүл мэндийн байгууллага бүр иргэд, үйлчлүүлэгчдийн оношийг цаг алдалгүй, үнэн зөв тогтооход чиглэгдсэн “Сэтгэлд нийцсэн оношилгоо”–ны удирдамжтай байна.

6.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн оношилгоо”–ны удирдамжаар нийт ажилтнууддаа сургалт явуулах ажлыг хариуцна.

6.4. “Сэтгэлд нийцсэн оношилгоо” нь тухайн байгууллагын иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөтөлбөрийн салшгүй хэсэг нь байна.

6.5. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн оношилгоо”–ны үзүүлэлтийг ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх гол шалгуур үзүүлэлт болгоно.

#### Долоо. Сэтгэлд нийцсэн эмчилгээ

7.1. “Сэтгэлд нийцсэн эмчилгээ” гэж өвчтөнийг гэрээр, өдрөөр, амбулаториор, эмнэлэгт хэвтүүлж цаг алдалгүй, хүндрэлгүй, үр дүнтэй эмчлэх тусламж, үйлчилгээг хэлнэ.

7.2. Эрүүл мэндийн байгууллага бүр өвчтөнийг цаг алдалгүй, үр дүнтэй эмчлэхэд чиглэгдсэн “Сэтгэлд нийцсэн эмчилгээний”–ний удирдамжтай байна.

7.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн эмчилгээ”-ний удирдамжаар нийт ажилтнууддаа сургалт явуулах ажлыг хариуцна.

7.4. “Сэтгэлд нийцсэн эмчилгээ” нь тухайн байгууллагын иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын хөтөлбөрийн салшгүй хэсэг нь байна.

7.5. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн эмчилгээ”-ний үзүүлэлтийг ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх гол шалгуур үзүүлэлт болгоно.

#### Найм. Сэтгэлд нийцсэн сувилгаа

8.1. “Сэтгэлд нийцсэн сувилгаа” гэж иргэд, үйлчлүүлэгчдийг эмнэлэг, сувилал, гэрээр нь анхаарал, болгоомжтой, сэтгэл гаргаж асарч сувилах тусламж, үйлчилгээг хэлнэ.

8.2. Эрүүл мэндийн байгууллага бүр анхаарал, болгоомжтой, сэтгэл гаргаж асарч сувилах тусламж, үйлчилгээг хэрэгжүүлж хэвшүүлэхэд чиглэсэн “Сэтгэлд нийцсэн сувилгааны”-ны удирдамжтай байна.

8.3. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн сувилгаа”-ны удирдамжаар нийт сувилагч, туслах сувилагчиддаа сургалт явуулах ажлыг хариуцна.

8.4. “Сэтгэлд нийцсэн сувилгаа” нь тухайн байгууллагын иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын хөтөлбөрийн салшгүй хэсэг нь байна.

8.5. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн сувилгаа”-ны үзүүлэлтийг ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх гол шалгуур үзүүлэлт болгоно.

#### Ес. Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх эмчилгээ

9.1. “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх эмчилгээ” гэж эмчлэгдэх боломжгүй хүндэрсэн өвчтэй иргэдийг амьдралынх нь сүүлчийн өдрүүдэд зовиур шаналгаа багатай, халамж, анхаарал тавьж эмчилж сувилах тусламж үйлчилгээг хэлнэ.

9.2. Эрүүл мэндийн байгууллагууд нь эмчлэгдэх боломжгүй хүндэрсэн өвчтэй иргэдийг амьдралынх нь сүүлчийн өдрүүдэд зовиур шаналгаа багатай, халамж, анхаарал тавьж эмчилж, сувилахад чиглэгдсэн “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ”-ний удирдамжтай байна.

9.3. “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж эмчилгээ”-ний удирдамжаар хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч, туслагч сувилагчдад зориулж сургалт явуулах ажлыг хариуцна.

9.4. “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж эмчилгээ” нь тухайн байгууллагын иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын хөтөлбөрийн салшгүй хэсэг нь байна.

9.5. Эрүүл мэндийн байгууллага бүр “Сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх тусламж эмчилгээ”-ний үзүүлэлтийг ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэх гол шалгуур үзүүлэлт болгоно.